





**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ  
2019 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ТАЛААР БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

2019.12.16

№	Хийж гүйцэтгэх ажил	Хэрэгжилт	Хувь
<b>Нэг. Хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа, Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн бүртгэлийн чиглэлээр</b>			
1.1	Шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төсөл, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад тухай бүр дэмжлэг үзүүлэх	Шинээр батлагдан гарсан Төрийн албаны тухай хууль болон түүнтэй холбогдон гарсан дүрэм журам, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Зөрчлийн тухай, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай, Хөдөлмөрийн тухай, Нотариатын тухай, Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тухай, Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Татварын ерөнхий хууль тогтоомжуудыг сурталчлах, сургалт зохион байгуулах ажлыг илүүтэй тухай бүр зохион байгуулсан. Захиргааны хэм хэмжээ тогтоосон акт бэлтгэх, боловсруулах, батлуулахад анхаарах асуудлаар сумдын ЗДТГ-ын дарга нарт 1 удаа сургалт, мэдээлэл зохион байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж тухай бүр арга зүйгээр хангаж ажиллаж байна. 2019 онд аймгийн хэмжээнд аймаг, сумдын ИТХ, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын хамтран баталсан зэрэг захиргааны хэм хэмжээ тогтоосон нийт 23 эрх зүйн актыг бэлтгэх, боловсруулах, батлуулахаар холбогдох ажиллагаа зохион байгуулахад нь зохих арга зүйгээр хангаж, шаардлагатай дэмжлэг, зөвлөгөө, туслалцаа үзүүлж хамтран ажиллаж улсын нэгдсэн санд бүртгүүлээ. 2019 онд шинэ тутам хууль тогтоомжоор сургалт, сурталчилгаа зохион байгуулахад оно нутгийн төсвөөс 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, сумдад “Эрх зүйн хөтөч” бэлтгэх, “Хууль тогтоомж сурталчлах өдөрлөг” зэрэг арга хэмжээнд зарцуулсан.	100
1.2	“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг аймаг, нийслэл орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ХЗДХ-ийн сайдын баталсан төлөвлөгөөтэй нийцүүлэн баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах	“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний аймгийн төлөвлөгөөг Хууль, зүйн сайдын баталсан төлөвлөгөөтэй уялдуулан 2018-2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2018 оны 8 дугаар сарын 15-ны өдөр аймгийн Засаг даргаар батлуулан, тус онд 98.5 хувийн хэрэгжилттэйгээр хэрэгжүүлэн ажиллалаа.	100

Хүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний аймгийн төлөвлөгөө (2018-2019 он)					
Хөтөлбөрийн зорилго: Иргэдийн эрэлт сонирголтоо хангахад эрх зүйн мэдлэг, мэдлэгийг цэвэр болгох, тус болгоход зориулж иргэдийн эрх зүйн мэдлэгийн хөгжлийг хангах, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих.					
№	Үйл ажиллагаа	Батлагдсан	Шатруу үзүүлэлт	Хэрэгжилт	Харгалсан хугацаа
Зорилт 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг өсгөх, эрх зүйн мэдлэг, мэдлэгийг цэвэр болгох, тус болгоход зориулж иргэдийн эрх зүйн мэдлэгийн хөгжлийг хангах, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих.					
1.1.1	ХЗДХ-ийн байршил эрх зүйн сургалт сурталчилгааны үйлчилгээг хөгжүүлэх, тусгай зориулалттай эрх зүйн мэдлэг, мэдлэгийг цэвэр болгох, тус болгоход зориулж иргэдийн эрх зүйн мэдлэгийн хөгжлийг хангах, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих.	Шатруу үзүүлэлт	Хэрэгжилт	ХЗДХ	ХЗДХ
Үйл ажиллагааны нэвтрүүлэг: 1.1.1. Эрх зүйн мэдлэг, мэдлэгийг цэвэр болгох, тус болгоход зориулж иргэдийн эрх зүйн мэдлэгийн хөгжлийг хангах, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих.					
1.1.2	ХЗДХ-ийн байршил эрх зүйн сургалт сурталчилгааны үйлчилгээг хөгжүүлэх, тусгай зориулалттай эрх зүйн мэдлэг, мэдлэгийг цэвэр болгох, тус болгоход зориулж иргэдийн эрх зүйн мэдлэгийн хөгжлийг хангах, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих.	Шатруу үзүүлэлт	Хэрэгжилт	ХЗДХ	ХЗДХ
Үйл ажиллагааны нэвтрүүлэг: 1.2. Иргэдийн эрэлт сонирголтоо хангахад эрх зүйн мэдлэг, мэдлэгийг цэвэр болгох, тус болгоход зориулж иргэдийн эрх зүйн мэдлэгийн хөгжлийг хангах, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих, эрх зүйн мэдлэгээр хөгжсөн иргэдийн хөгжлийг дэмжих.					
1.2.1	Хууль, зүйн сайдын баталсан төлөвлөгөөтэй уялдуулан 2018-2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2018 оны 8 дугаар сарын 15-ны өдөр аймгийн Засаг даргаар батлуулан, тус онд 98.5 хувийн хэрэгжилттэйгээр хэрэгжүүлэн ажиллалаа.	Сурталчлагдсан	Хэрэгжилт	ХЗДХ	ХЗДХ
1.2.2	Хууль, зүйн сайдын баталсан төлөвлөгөөтэй уялдуулан 2018-2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2018 оны 8 дугаар сарын 15-ны өдөр аймгийн Засаг даргаар батлуулан, тус онд 98.5 хувийн хэрэгжилттэйгээр хэрэгжүүлэн ажиллалаа.	Гаргасна	Хэрэгжилт	ХЗДХ	ХЗДХ

1.3	<p>“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Эрх зүйн хөтчөөр бэлтгэгдэх иргэдийг сонгох, бэлтгэх, үйл ажиллагаанд Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтарч ажиллах, эрх зүйн хөтчийг ажиллуулах</p>	 <p>“Эрх зүйн хөтөч” орон тооны бус багийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, үндэсний тогтолцоог төрийн болон төрийн бус бүтцээр дамжуулан бий болгох зорилготой сум бүрт 4 эрх зүйн хөтөч буюу аймгийн хэмжээнд нийт 64 эрх зүйн хөтчийг Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран бэлтгэж, тус оны 9 дүгээр сараас Эрх зүйн хөтөч бүртэй гэрээ байгуулан ажиллалаа. Эрх зүйн хөтөчийг бэлтгэх үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 10,0 сая төгрөгийг шийдвэрлэн дэмжлэг үзүүлэн ажилласан. Эрх зүйн хөтөч бүрийг 3 төрлийн гарын авлага ном товхимол, 15 төрлийн хууль тогтоомжоор бэлтгэсэн 15ш шторк, богино хэмжээний 6 киногоор тус тус ханган, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулсан.</p> 	100
1.4	<p>Хууль зүйн зөвлөгөө мэдээллийн цахим сан <a href="http://www.e-khutuch.mn">www.e-khutuch.mn</a> цахим хуудсыг орон нутагт хариуцан ажиллах албан тушаалтныг тусгайлан томилж, ажил үүргийн тодорхойлолтод нь уг чиг үүргийг тусган Хууль зүйн үндэсний хүрээлэнд мэдээлж, хамтран ажиллах</p>	<p>Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомж системчлэл, лавлагаа, хүний эрх, ГХУС ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тушаалын тодорхойлолтод <a href="http://www.e-khutuch.mn">www.e-khutuch.mn</a> цахим хуудсыг орон нутагт хариуцан ажиллах чиг үүргийг тусган, Хууль зүйн үндэсний И-хөтөч цахим сангийн хүрээлэнд мэдээлсэн. мэдээлэлд сум, байгууллагуудын мэдээллийг бүрэн оруулж, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн холбогдох ажилтанд хүргүүлж хамтран ажиллалаа.</p> 	100
<b>Хоёр. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>			
2.1	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, ГХУС33-ийн хурлаар батлуулж, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулж төлөвлөгөө болон үр дүнг хагас, бүтэн жилээр Хууль, дотоод хэргийн яаманд тайлагнах.</p>	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн төлөвлөгөөг ГХУС33-ийн 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн I хурлаар батлуулан, байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж, хэрэгжилтийг эхний хагас жилд 2019.06.20-ны өдөр 1/93 албан бичгээр, жилийн эцсийн тайлан мэдээг 2019.12.09-ны өдрийн 1/166 албан бичгээр тус тус хугацаанд нь ХЗДХЯ-нд тайлагнасан.</p> <p>Аймгийн Цагдаагийн газраас гэмт хэрэг, захиргааны зөрчлийн гаралтын талаарх мэдээллийг сар бүрээр гарган, нөхцөл байдалд дүгнэлт, судалгаа хийж, Цагдаагийн Ерөнхий газрын холбогдох хэлтэс, нэгж, аймаг сумдын Засаг дарга нар, ГХУСАЗ Зөвлөлүүдэд нийт 141 удаа танилцуулга мэдээлэлд 308 санал хүргүүлж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хамтран зохион</p> 	100

байгуулан ажилласан.Төлөвлөгөөний дагуу болон холбогдох дээд байгууллагаас ирүүлсэн удирдамж, чиглэлийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Сар шинэ-2019”, “Нэг хором” нэгдсэн арга хэмжээ, “Гэрэлтэй орчин-Аюулгүй бүс”, “Эргүүл хяналт шалгалт”, “Зөв тусгал”, “Яараад яахав дээ”, “Орон нутгийн зам, хөдөлгөөний соёл”, “Оюутан тээвэр”, “Дураараа бишээ дүрмээрээ”, “Эко-2019”, “Цэрэг”, “Ухамсар”, “Ойлгоё-Хүндэлье” зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд сурагчдыг хүний эрүүл мэндийн гэмт хэрэг, зам тээврийн гэмтлээс урьдчилан сэргийлэх,



хамтын үйл суралцагчид болон багш нэмэгдүүлэх, сургууль "Гэмт хэрэг зөрчилгүй дунд сургуулийн хэмжээнд



ажиллагааг ажилчдын хууль эрх зүйн мэдлэгийг орчмын аюулгүй бүсийг бий болгох зорилгоор сургуулийн орчин” болзолт уралдааныг аймгийн 20 зарлан явуулж үр дүнг тооцсон. Аймгийн Гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран “Гэмт хэрэг зөрчилгүй байгууллага” шалгаруулах болзолт уралдаан зарлаж үр дүнг тооцсон. 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөх Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, Зөрчлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудаар төрийн байгууллагуудын 1543 хүнийг хамруулан сургалт зохион байгуулсан. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр аймгийн Засаг даргаас сумдын Засаг даргатай хамтран ажиллах 2019 оны гэрээний дагуу тодорхой заалтууд оруулж, хяналт тавьж ажилласны дүнд Адаацаг, Хулд сумд тус бүр орон нутгийн төсвийн 10 сая төгрөгийн хөрөнгөөр 8 ширхэг хяналтын камер, Баянжаргалан сум 4.5 сая төгрөгийн хандив тусламжаар 4 ширхэг хяналтын камерыг тус тус шийдвэрлэж, ашиглалтад оруулсан. Сумдын ГХУССЗөвлөлүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд олон нийттэй хамтран ажиллах, сурталчилгаа мэдээллээр хангах ажилд нь дэмжлэг үзүүлж аймгийн ГХУССЗЗ-өөс 8.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. ГХУССЗЗ-өөс дэмжлэг үзүүлж Зам тээврийн осол хэрэг давтагдан гарч буй хар цэгийн судалгааг гаргаж, урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд сурталчилгаа, мэдээлэл хүргэж, аймгаас хойш 30 км-т гэрэл ойлгогчтой анхааруулах самбар байрлуулж, техник замын хяналтын чиглэлээр “Замын тэмдэг, тэмдэглэлийн бүрэн бүтэн байдал” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан. Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад хотыг холбосон орон нутгийн замд зам тээврийн


байгууллагуудын сайжруулах



		<p>осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтын ажиллагаагаа сайжруулж, уг хамтын ажиллагааны хүрээнд Өмнөговь аймгийн ИТХ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс тус аймгийн ГХУСАЗЗ, Цагдаагийн газарт PRIUS-20 маркын авто машины хамт эргүүл хяналт шалгалтанд ашиглагдах драгерь, тандагч багаж, станцын хамт шийдвэрлэж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Төлөвлөгөөний дагуу болон аймгийн Цагдаагийн газар, холбогдох дээд байгууллагаас зохион байгуулсан гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнд аймгийн Засаг дарга, ГХУСАЗЗ-өөс зохих санхүүжилт дэмжлэгийг тухай бүр үзүүлж ажилласны дүнд төлөвлөгөөний биелэлт 2019 оны 6 дугаар сард 87%, 2019 оны 12 дугаар сард 90%-тай хувьтай гарч, аймгийн хэмжээнд гэмт хэрэг 12 дугаар сарын 04-ний байдлаар 19.1%-иар буурч, илрүүлэлт 1%-иар өссөн.</p>	
2.2	<p>Архидалтгүй аймаг – Дундговь дэд хөтөлбөр (2018-2020)-ийг иргэд, ИНБ-ын оролцоотой төлөвлөн, хэрэгжүүлж, архидаг согтуурахтай тэмцэх чиглэлээр зөвлөгөөн зохион байгуулж, үр дүнг нэмэгдүүлэх</p>	<p>2018-2020 онд хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын 2018 оны А/231 дугаар захирамжаар батлагдсан “Архидалтгүй аймаг-Дундговь” дэд хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх 10 ажлын чиглэл батлуулж, сумдын ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллагуудад хүргүүлж, хяналт тавьж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран холбогдох дээд байгууллагаас ирүүлсэн удирдамж, чиглэлийн дагуу 2019 онд Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий нийт 116 аж ахуйн нэгж, архины 1 үйлдвэр, тамхи худалдаалах зөвшөөрөлтэй 64 цэгт холбогдох хууль тогтоомжийн дагуу нэгдсэн хяналт, шалгалтыг 2 удаа зохион байгуулж, “Сар шинэ-2019”, “Нэг хором” нэгдсэн арга хэмжээ, “Эргүүл хяналт шалгалт”, “Зөв тусгал” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээ, “Найрсаг соёлч үйлчилгээ” аяны хүрээнд тухай бүр согтууруулах ундаа борлуулах ажилд 18 нас хүрээгүй хүн ажиллуулах, 21 нас хүрээгүй хүнд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх болон бусад хуулиар хориглосон зөрчил гаргаж байгаа эсэхэд хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангах талаар санамж, сэрэмжлүүлэг бэлтгэн иргэд, олон нийтэд сурталчилж хамтран ажилласан. Дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулж, хяналт шалгалт хийж, давхардсан тоогоор 175 офицер, 255 цагдааг 9 автомашин ажиллуулж, хууль тогтоомж зөрчсөн 2 аж ахуйн нэгж, 5 иргэний зөрчлийг илрүүлж, торгуулийн арга хэмжээ авч ажилласан. “Гэмт хэрэг зөрчилгүй байгууллага” шалгаруулах болзолт уралдаан зарлан зохион байгуулж үр дүнг тооцэх зэргээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хариуцлага, сонор сэрэмжийг дээшлүүлэх, идэвхжүүлсэн. Аймгийн төв Сайнцагаан сумын ЗДТГ, ГХУСАЗСЗ-тэй хамтран архины хамааралтай зорилтод бүлгийн 21 иргэнийг хамруулсан сургалтыг зохион байгуулж, гэмт хэрэг зөрчилд холбогдохгүй байх талаар баталгаа авсан. “Говийн хийморь” АА бүлэгтэй хамтран тус бүлгийн 6 жилийн ойн арга хэмжээг 2019.04.27-ны өдөр зохион байгуулж, уулзалт цуглаанд архины хамааралтай зорилтот бүлгийн иргэдийг хамруулсан.</p>	70

2.3	<p>Хүүхдийн эсрэг үйлдэгддэг гэмт хэрэг болон хүүхдээс үйлдэгддэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодруулж эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх</p>	<p>Тус аймгийн хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр хуралдаанаар 2018 оны тайлан, 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө хэлэлцэн аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүнээр 31 заалт бүхий ажлын төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 2019 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 82%-тай байна. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, Боловсрол соёл урлагийн газартай хамтран 14 сумын Ерөнхий боловсролын сургуулийн 5-12 дугаар ангийн 1052 сурагчдад Цахим гэмт хэрэг, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Хорт зуршил түүний хор хөнөөлийн талаар сургалтыг зохион байгуулж, 14 сумын 17 өсвөр насны хүүхдэд мэргэжлийн сэтгэл зүйчээр сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө үйлчилгээ үзүүллээ. “Өсвөрийн сэргийлэгч 2019” тэмцээнийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран 6 үе шаттай зохион байгууллаа. 2019 онд гэмт хэрэгт холбогдон шүүхээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 2 хүүхдийг хөтөлбөрийн дагуу “Амьдрах ухааны үр чадвар эзэмшүүлэх 12 модуль сургалтад хамруулж, гэмт хэрэгт холбогдсон Дэрэн сумын 9 хүүхэд, тэдний асран хамгаалагчдад хууль эрх зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлж, Дундговь аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хүүхдүүдийн ялыг хөнгөлөх талаар албан бичгээр хүсэлт хүргүүлж, гэмт хэргийн хохирогч 2, гэрч 1 хүүхдийн хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын үед эрхийг нь хамгаалан хууль ёсны төлөөлөгчөөр оролцож нийт хагас жилийн байдлаар 14 хүүхдэд 8 төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 24 удаа үзүүлээд байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдүүдэд “Оюуны гэгээ” төрийн бус байгууллагын сэтгэл зүйч, нийгмийн ажилтнууд хамтран зан үйлийн албадан сургалтыг тогтмол зохион байгуулж хэвшүүлээ. Эдгээр ажлын үр дүнд 15 хүртэлх насны хүүхэд гэмт хэрэгт холбогдогсдын тоо 8 буюу 72,7 хувиар буурсан.</p>	100
<b>Гурав. Цагдаагийн байгууллагын чиглэлээр</b>			
3.1	<p>Олон нийтийн цагдаагийн ажилтны тоог нэмэгдүүлэх цалин урамшууллын асуудлыг шийдвэрлэж санхүүжүүлэх, ажлын үр дүнг тооцох</p>	<p>Тус аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 2019 онд ажиллах олон нийтийн цагдаагийн тоог 4 байхаар тогтоосон ба ажиллаж байсан олон нийтийн цагдаа нараас 1 нь цагдаагийн анхан шатны сургалтад шалгалт өгч тэнцэн тус цагдаагийн газарт хэсгийн цагдаагаар томилогдон ажиллаж, 1 олон нийтийн цагдаа ажлаасаа хүсэлтээрээ чөлөөлөгдсөн ба одоогоор тус аймгийн хэмжээнд 2 олон нийтийн цагдаа ажиллаж байна. Тэдний ажлын үр дүнг тооцож, урамшуулал олгодог. Аймгийн төвийн 5 багт тус бүр 5 хэсгийн ахлагч томилж</p>	100



		<p>үнэмлэхжүүлж, тэдний аюулгүй байдлыг хангах үүднээс аймгийн ГХУСАЗСЗ-с 875000₮ гарган гэрэлтүүлэгч хантаазыг шийдвэрлэсэн. ажиллах журмыг Тэргүүлэгчдийн хурлаар батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Олон нийтийн цагдаагийн таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас хэрэглэхтэй холбоотойгоор иргэд, олон нийтийн зүгээс ямар нэгэн гомдол, шүүмжлэл гараагүй. Олон нийтийн цагдаа нартай байгуулах хөдөлмөрийн гэрээг батлагдсан загварын дагуу хийж, олон нийтийн цагдаагаар ажиллах иргэн, Цагдаагийн газар, аймгийн ИТХ-ын удирдлага баталгаажуулсан. Олон нийтийн цагдаа нарыг аймгийн Цагдаагийн газраас өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар хангаж, бие бүрэлдэхүүнд зохион байгуулж байгаа албаны сургалт, бие бялдрын хичээлд хамруулж, нэгдсэн болон тусгай арга хэмжээний хүрээнд аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллага, худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэдэд баяр ёслолоо зүй зохистой тэмдэглэн өнгөрүүлэх, архи согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчил гаргуулахгүй байх, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх чиглэлээр албан мэдэгдэл, санамж сэрэмжлүүлэг тараах, хяналт тавих зэргээр урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж байна. Олон нийтийн цагдаа нар нийт 105 удаа 843 цагийн эргүүлийн үүрэгт ажлыг эргүүлийн цагдаа нарын хамт үүрэг гүйцэтгэн ажилласан. Ажиллах хугацаандаа нийт 57 зөрчил илрүүлж эргүүлийн цагдаа нарт шилжүүлэн торгуулийн арга хэмжээ тооцуулан ажилласан. Ахуйн дуудлаганд 14 удаа явж, 5 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд хүргэж, 25 иргэнийг ар гэр асран хамгаалагч нарт нь хүлээлгэн өгсөн байна. 2019 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж байгууллагын ажилчдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж 2019 онд аймгийн төвд төрийн 14 байгууллагын 28 албан хаагчийг 2-оос доошгүй цагаар гудамж талбайд эргүүл, шалгалтанд гарган ажиллуулсан. Дээрх ажил, арга хэмжээнүүдийн дүнд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 2019 оны 12 дугаар сарын 04-ний байдлаар бүртгэгдэж, өмнөх оноос 21.7%, Бусдын хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 47.6%-иар тус тус буурсан байна.</p>	
3.2	Сайнцагаан сумын цагдаагийн хэлтсийн барилга	<p>Цагдаагийн газрын шинээр баригдах барилгын ажлын тендер шалгаруулалтыг явуулах үнэлгээний хороог Аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/58 тоот захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан тендерийг зохион байгуулж, гүйцэтгэгчээр 1,849 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Ван хүү” ХХК шалгарсан. 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр ЦЕГ-ын даргатай ЦЕГ/201901005 дугаартай гэрээг байгуулж, барилгын ажлыг эхлүүлж, хугацаанд нь ажлаа гүйцэтгэж, аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын Газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/59 тоот тушаалаар барилга ашиглалтанд оруулах Улсын комисс ажиллаж, ашиглалтанд хүлээн авахад бэлэн болсон.</p>	 <p>100</p>

3.3	Хулд суманд Замын хөдөлгөөний хяналтын пост барих		<p>Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлийн хатуу хучилттай зам дагуу тус аймгийн Хулд суманд Замын хөдөлгөөний хяналтын пост шинээр барихаар 2019 оны улсын төсөвт 79 сая төгрөг батлагдсаны дагуу ЦЕГ-ын даргатай “ГЭЭТ” ХХК ЦЕГ/201901001-5 гэрээ байгуулан хугацаандаа ажлаа гүйцэтгэж аймгийн аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын Газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/60 тоот тушаалаар барилга ашиглалтанд оруулах улсын комисс ажиллаж, ашиглалтанд оруулах шийдвэр гарсан.</p>	100
<b>Дөрөв. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:</b>				
4.1	ШШГГ-ын эрх зүйн сургалтын танхим номын сан, шүүхийн шийдвэрээр хураагдсан эд хөрөнгийг хадгалах байр зэргийг засварлан тохижуулахад дэмжлэг үзүүлэх		<p>Аймгийн ШШГГ нь эрх зүйн сургалтын танхим, номын санг дотоод нөөц боломжид тулгуурлан тохижуулж, шүүхээр оногдуулсан зан үйлийг засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтыг бүрэн зохион байгуулж ажиллалаа. Тухайлбал: Зан үйл засах сургалтыг 14 хоног тутам онлайн хэлбэрээр зохион байгуулж сургалтын чанар, үр нөлөөтэй зохион байгуулахад онцгой анхааран ажилласан ба тус хугацаанд нийт 4 ялтанд 22 цагийн лекц хичээлийг зохион байгуулсан. Мөн тэдэнд хөдөлмөрлөх дадал олгох сургалтыг “Ирээдүй” сургалтын төв, Ганхөлөг констракшн ХХК зэрэг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, мэргэжлийн батламж, үнэмлэхийн хамт олгосон. Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын хүрээнд аж ахуйн үйлчилгээнд ял эдэлж байгаа 4 хоригдолд “Архины хор уршиг”, “Тамхины хор уршиг”, “Эрүүгийн хууль”-ийн зарим зүйл заалтаар хичээл сургалтыг зохион байгуулсан. Улс орны улс төр, нийгэм, эдийн засгийн холбоотой болоод бусад мэдээлэл өгөх зорилгоор өдөр тутмын “Зууны мэдээ” сонин, 7 хоног тутмын “Дундговийн амьдрал” зэрэг сонин хэвлэл, бусад гарын авлага, зөвлөмж боловсруулан газрын номын сангаар үйлчлэхийн зэрэгцээ унших номын төрлийг олшруулах зорилгоор С.Буяннэмэхийн нэрэмжит Төв номын сантай гэрээ байгуулан Зөврийн номын сангаар 14 хоногт 1 удаа санал хүсэлтэнд тулгуурлан 12 хоригдол, хоригдогчид /давхардсан тоогоор/ 96 ширхэг номоор үйлчилсэн байна.</p>	70
<b>Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр</b>				

5.1	Төрийн архивын орчин үеийн шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх	<p>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн архивын баримтын хадгалалт, тохиромжтой нөхцлийг байдлын хангах ажлын төгрөгийн хөрөнгийг Засаг даргын Тамгын газар 8 нягтруулсан шүүгээ, галын дохиоллын систем, төмөр төхөөрөмжийг суурилуулах аар гүйцэтгүүлсэн. Төрийн архивын 2 хадгаламжийн сангийн 90м кв талбайд шавьжгүйдэлийн ариутгалыг “Сайн түшиг” ХХК хийлгэсэн.</p> 	<p>хамгаалалтын бүрдүүлэх, аюулгүй хүрээнд 5,090,000 шийдвэрлэж, аймгийн болон архивын тасагт нийт хор, чийгшүүлэгч, хаалга зэрэг тоног ажлыг “Сити Сейф” ХХК-</p>	100
5.2	“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж 10 хөмрөг үүсгэгч байгууллагын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	<p>“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 4 дэх үе шатны зорилтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 28 хөмрөг үүсгэгч байгууллагыг цахим санд оруулахаар төлөвлөснөөс 2019 оны 11 сарын 30-ны байдлаар дараах ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. 14 хөмрөгийн 194 ХН буюу 21378 хуудас баримтанд тодорхойлон бичилт хийж.</li> <li>2. 22 хөмрөгийн 542 хадгаламжийн нэгж буюу 47860 хуудас баримтыг скайнердаж хамгаалалтын ба ашиглалтын хувь үйлдэж,</li> <li>3. 26 хөмрөгийн 711 хадгаламжийн нэгж буюу 55264 хуудас баримт засварлаж,</li> <li>4. 28 хөмрөгийн 573 хадгаламжийн нэгж буюу 58816 хуудас баримтанд холболт хийж цахим санд оруулаад байна.</li> </ol>		100
5.3	Баянхонгор аймагт 2019 онд зохион байгуулах үзүүлэх сургалтад албан хаагчдаа хамруулах, шаардагдах зардлыг шийдвэрлэх	<p>Архивын Ерөнхий газар, Баянхонгор аймгийн ЗДТГ-аас хамтран зохион байгуулсан архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох 2 өдрийн нэгдсэн сургалтанд аймгийн ЗДТГ-ын дарга, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгч, аймгийн ЗДТГ-ын архивын ажилтан нар оролцож, Баянхонгор аймгийн архивын шинэ байрны хадгалалт, хамгаалалтын талаар туршлага судалж, мэдлэг мэдээлэл солилцсон. Тус сургалтанд оролцох зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газраас хангаж ажиллалаа.</p>		100
5.4	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын удирдлага зохион байгуулалтын улсын үзлэгийг 2019 онд зохион байгуулахтай холбогдуулан бэлтгэл ажлыг хангах	<p>МУЗГ-ын 2019 оны 150 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн удирдамж чиглэлийн дагуу АЕГ-тай хамтран сургалтыг 05 сарын 17-ний өдөр зохион байгуулахаар удирдамж хөтөлбөрийг батлуулж, аймгийн Засаг даргын 2019 оны А/185 захирамжаар улсын үзлэгийн салбар комиссын бүрэлдэхүүнийг байгуулж 15 сум 23 байгууллагад урьдчилсан үзлэгийг зохион байгуулав.</p>		100



		Мөн Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн төв комиссоос , ИТХурал, аймгийн ЗДТГазар, Адаацаг, Өндөршил сумын ЗДТГазар, Боловсрол соёл, урлагийн газар, Нийгмийн даатгал хэлтэс, УЦУОШАлба зэрэг сум, байгууллагуудад 10 дугаар сарын 7-13-ныг хүртэл улсын үзлэг явагдаж 90.3 буюу “А” үнэлгээтэй дүгнэгдсэн.	
<b>Зургаа. Улсын бүртгэлийн чиглэлээр</b>			
6.1	Улсын бүртгэлийн үйлчилгээний шуурхай байдлыг хангаж нэг цэгийн үйлчилгээний чанар хүртээмж, тохижилтыг сайжруулах арга хэмжээг үе шаттай шийдвэрлэх.	Аймгийн Нэг цэгийн үйлчилгээний танхимаар Иргэний бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ, архивын үйлчилгээг иргэдэд үзүүлэн ажиллаж байна. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн ажлын хүрээнд цахим үйлчилгээний буланг тохижуулж <a href="http://www.burtgel.mn">www.burtgel.mn</a> сайтын орчинд иргэдэд үйлчилгээ үзүүлэн, мэдээлэл, зааварчилгаа өгч цахим орчноос мэдээллээ хэрхэн авах талаар үзүүлэх дадлага хийлгэж лавлагааг хэвлэн олгож байна. Аймгийн Нэг цэгийн үйлчилгээний танхимаар 2019 онд 6501 хүн үйлчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 24 хувиар өссөн дүнтэй байна.	100
<b>Долоо. Шүүхийн шинжилгээний чиглэлээр</b>			
7.1	Шүүхийн шинжилгээний албаны автомашиныг тоноглох, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх.	Шүүхийн шинжилгээний албаны алба хаагч нар шаардлагатай үед ашиглах боломжтой зориулалтын багаж хэрэгсэл бүхий 2 ширхэг цүнх шийдвэрлүүлсэн. Албаны автомашиныг тоноглоход шаардлагатай тоног төхөөрөмжийн төрөл, өртөгийн судалгааг боловсруулж, хөрөнгө санхүүг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллага, албан тушаалтанд хүсэлт хүргүүлсэн. Төсвийн тухай хуультай зөрчилдөж, ИТХ-аас орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дэмжигдээгүй болно.	30
<b>Найм. Гадаадын иргэн, харьяатын чиглэлээр</b>			
8.1	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.6-д заасныг хэрэгжүүлж ажиллах.	Тус аймгийн сумдад оршин суугаа гадаадын иргэний хаягийн бүртгэлийн мэдээг нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн харьяатын газарт хагас жил тутам гаргаж өгч байна.	100
<b>Ес. Хууль сахиулах салбарын хүний нөөцийг чадваржуулах, давтан сургах чиглэлээр</b>			
9.1	Сумдын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарыг хамруулан “Аюулгүй байдлын үндэс Стратегийн дамжаа” богино хугацааны сургалтыг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах	Сумдын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, Төрийн албаны тухай хуулиар мэргэжлийн байгууллагуудтай хамтран тусгайлан сургалт зохион байгуулсан. 2019 онд сумдад бэлтгэсэн “Эрх зүйн хөтөч” нартай хамтран сум бүрт “Хууль тогтоомж сурталчлах” өдөрлөгийг зохион байгуулах үеэр сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга буюу сумын ГХУСЗ-ийн дарга удирдлагуудтай уулзаж, сумын ГХУСАЗЗ-ийн ажилтай танилцаж, шаардлагатай талаар зөвлөмж, мэдээллээр хангасан. Аймгийн ИТХ, Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Салбар Зөвлөлөөс аймгийн Цагдаагийн газар, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүх, Өмгөөлөгчдийн зөвлөл, Шүүхийн шинжилгээний албаны 70 гаруй алба хаагч нарыг оролцуулан "Хууль эрх зүйн сургалт, зөвлөгөөн зохион байгууллаа. Тус сургалт, зөвлөгөөнд Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн гишүүн Г.Туулхүү, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн тусгай шинжилгээний газрын лабораторын эрхлэгч Дэд хурандаа Б.Ламчин, ДХИС- ийн тэргүүн дэд	100

		захирал, хууль зүйн ухааны доктор, дэд профессор Б.Бат-Эрдэнэ, УЕПГ-ын Сургалтын төвийн дарга М.Гантулга, УЕПГ-ын сургалтын төвийн сургагч багш, хяналтын прокурор Г.Оюунболд, Монгол Улсын Төрийн албаны Зөвлөлийн гишүүн Д.Зүмбэрэллхам нар урилгаар оролцож хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын өнөөгийн байдал, хийгдэж буй шинжилгээ, урьдчилан сэргийлэх тухай, шинэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх арга зүйн тактик, түүний зарим асуудал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх арга замууд болон хүний наймаа түүнээс урьдчилан сэргийлэх арга зам сэдвүүдээр сургалт зохион байгуулж оролцсон.	
<b>Арав. Хууль зүйн туслалцааны чиглэлээр</b>			
10.1	Тухайн орон нутгийн Засаг даргын зүгээс Хууль зүйн туслалцааны төвийн салбарын үйл ажиллагааг дэмжиж, шаардлагад нийцсэн ажлын өрөө, тасалгаагаар хангах, урсгал зардлыг хариуцах, интернетийн орчинг бүрдүүлэх	Хууль зүйн туслалцааны төвийн тус аймаг дахь өмгөөлөгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажлын өрөө, тасалгаагаар бүрэн хангаж, интернет бүхий орчинг бүрдүүлэн, урсгал зардлыг аймгийн ЗДТГ-аас хариуцаж хэвийн ажиллуулж хэвшүүлсэн. Тус онд эрүүгийн 48 хэргийн төлбөрийн чадваргүй 56 холбогдогчдод өмгөөллийн үйлчилгээг Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч үзүүлсэн. Хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг 360 иргэнд үзүүлсэн.	100
Дундаж хувь		100 хувь-17; 70 хувь-2; 30 хувь-1	93.5

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ТҮВШИНБАЯР

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН

ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ОДОНЧИМЭГ